

гэхэд 10,000 хүн ам тутамд ногдох хүний бруцеллёзын өвчлөл 0,01 болтлоо буурсан. Гэвч 1990 оноос хойш мал хувьчлагдан, малыг бруцеллёзын шинжилгээнд хамруулах, вакцинжуулах, халдвар авсан малыг хэрэгцээлэх ажилд бэрхшээл учирсан нь хүн, малын бруцеллёзын өвчлөл нэмэгдэх шалтгаан болсон (Энхбаатар.А, бусад, 2004).

Манай улсад сүүлийн 10 жилийн байдлаар хүний бруцеллёз өвчнөөр жилд 300-500 хүн шинээр өвчилж, өвчлөгсдийн 53%-ийг малчид эзэлж, 66% нь эмэгтэйчүүд байна (Батаа.Ж, бусад, 2009). Монгол улсад хүний бруцеллёз өвчнийг мэдээлэгдэхгүй байгаа тохиолдлын тоо нэн өндөр ба 1:40 байна (Рот Феликс, 2006). Иймд хүн, малын дундах бруцеллёз өвчний бодит тархалт, өвчлөлд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлах зайлшгүй шаардлага тулгарч байна.

**Зорилго:** Хүн, мал, амьтны дундах бруцеллёз өвчний тархалт, малаас хүнд халдвар дамжихад нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлсийг судлах

**Материал, арга зүй:** Сүхбаатар аймгийн Дарьганга, Сүхбаатар, Түвшинширээ, Халзан зэрэг 4 сумын 8 багийн 83 хот айлын нийт 318 малчид, тэдгээрийн гэр бүлийнхнийг энгийн санамсаргүй аргаар сонгон, судалгаанд оролцох талаар таниулах зөвшөөрөл авч, хот айл, мал, хувь хүнээс авах 50 асуулт бүхий 3 төрлийн асуумжаар нүүр тулж харилцан ярилцах байдлаар судалгаа авсан. Судалгаанд хамрагдагсдаас стандарт аргачлалын дагуу вакуумтейнерын иж бүрдэл ашиглан цус авч, ийлдсийг хурилдаурдан ялган, зөөврийн хөргүүрт тээвэрлэн ирж, ХӨСҮТ-ийн Бруцеллёзын ийлдэс судлалын лабораторид Энэтхэг улсын “Тулип диагностик” пүүст үйлдвэрлэсэн Розе бенгалын оношлуураар тавиур шилний тунадасжих урвал тавьж, уг урвалаар эерэг гарсан ийлдсүүдэд шингэрүүлсэн Розе бенгалын урвалын шинжилгээг давтан хийсэн. Мөн нийт ийлдсэнд бруцеллын эсрэг иммуноглобулин G илрүүлэх шинжилгээг АНУ-ын “Диагностик автомешн” пүүсийн оношлогооны цомог ашиглан үйлдвэрлэгчийн зааврын дагуу шууд бус фермент холбоот урвалаар шинжилсэн. Стандарт болон шингэрүүлсэн Розе бенгалын урвалаар эерэг, бруцеллын эсрэг иммуноглобулин G илрүүлэх шинжилгээгээр сөрөг гарсан нийт 20 ийлдсэнд Франц улсын “Нова Лиза” пүүсийн оношлогооны цомгийг ашиглан бруцеллын эсрэг иммуноглобулин M илрүүлэх шинжилгээг фермент холбоот урвалаар хийсэн. Судалгаанд 260 (81,8%) малчин, 58 (18,2%) тэдний гэр бүлийн гишүүдийг хамруулсаны 50,6% (161) эрэгтэй, 49,4% (157) нь эмэгтэй байна. Дээрх 4 сумаас 1682 хонь, 1671 ямаа, 359 үхэр, 118 тэмээ, 228 адуу, 65 гэрийн тэжээмэл нохой нийт 4123 толгой мал, амьтныг санамсаргүйгээр сонгон авч ийлдэс судлалын шинжилгээнд хамруулж, халдварлалтын

түвшинг тогтоосон. Судалгааны мэдээллийг Аксес-2007 программ дээр давхар оруулж, Эпи-Инфо программ дээр ялгааг шалган, Стата 10.1 программ дээр боловсруулалт хийсэн. Өвчлөлд нөлөөлж буй хүчин зүйлийг хи квадрат, фишерс экзаст тестээр тооцсон.

#### Дүгнэлт

1. Малчид тэдгээрийн гэр бүлийнхний дунд хүний бруцеллёзын тархалтыг 95%-ийн итгэх хязгаарт тооцож үзэхэд 28,6% байна (95% CI 23.9-33.8).

2. Ийлдэс судлалын шинжилгээгээр эерэг гарсан 91 хүнд судалгаа хийхэд нуруу өвдөх ( $p=0.004$ ), ядрах ( $p=0.006$ ) зэрэг эмнэл зүйн шинж тэмдгүүд илрэх нь бруцеллёз өвчний үед зонхилон тохиолдож байна.

3. Бог малын шүүрхий элэг идэх нь бруцеллёзын халдварт өртөхөд нөлөөлж байна ( $p=0.027$ ).

4. 45 ба түүнээс дээш насны малчид бруцеллёзын халдварт илүүтэй өртөж байна ( $p=0.001$ ).

## ХДХВ/БЗДХ-ын харуулдан тандалтын судалгаа 2009

Б.Оюунбилэг<sup>1</sup>, Э.Долгион<sup>1</sup>, Ч.Байгалмаа<sup>1</sup>, Ч.Бямбаа<sup>2</sup>

<sup>1</sup> Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

<sup>2</sup> Глобаль сан

ХДХВ-ийн халдвар нь дэлхийд хурдацтай тархаж буй улс орнуудын нийгэм, эдийн засагт ихээхэн хор хохирол учруулж байна. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хийсэн тооцоололтоор дэлхий дахинд 33.4 сая хүн ХДХВ-ийн халдвартай амьдарч байгаа бөгөөд жил бүр 2.7 сая хүн шинээр халдвар авч, 2 сая хүн ДОХ-ын улмаас нас барж байна. Монгол улсад 2010 оны 10 сарын 15-ны байдлаар ХДХВ/ДОХ-ын 83 тохиолдол бүртгэгдсэнээс 22 хүн ДОХ-ын шатандаа шилжиж ретровирусийн эсрэг эмчилгээ (РВЭЭ) хийлгэж байна. НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр болон ДЭМБ-ын хийсэн тооцоололтоор 2010 онд Монгол улсад < 500 хүн ХДХВ-ийн халдвартай байна. ХДХВ-ийн халдварын тархалтыг харуулдан тандах судалгаа нь ХДХВ-ийн халдварын тархалтыг хянах, зорилтот үйл ажиллагааг төлөвлөх, үнэлэхэд шаардлагатай тархварзүйн мэдээний эх сурвалж болдог.

**Зорилго:** ХДХВ/БЗДХ-ын харуулдан тандалтын судалгааг хүн амын тодорхой бүлгийн дундах ХДХВ, БЗДХ-ын тархалтыг тогтоох, халдварт өртөх эрсдэлтэй зан үйлийг тодорхойлох.

**Материал, арга зүй:** Уг судалгааг нэг агшны арга ашиглан хийв. Судалгааны хүн амыг Улаанбаатар хот, 21 аймгаас энгийн санамсаргүй түүвэрлэлтээр сонгон авав.

Энэ удаагийн харуулдан тандалтын судалгаагаар

ХДХВ, тэмбүүгийн халдварыг илрүүлэх ийдэс судлалын тандалт судалгаа (ИСС), БЗДХ-ыг илрүүлэх молекул биологийн судалгаа (МБС), Зан үйлийн тандалт судалгааг (ЗҮС) хийв. ИСС болон МБС-нд судалгаанд хамрагдсан хүн амаас цус, үтрээ болон умайн хүзүүний сувгаас сорьц цуглуулж ХДХВ, тэмбүү, заг хүйтэн, хламид, трихомониазийн халдвар илрүүлэх шинжилгээ хийв. ЗҮС-нд тусгайлан боловсруулсан асуумж, ярилцлагаар хэлбэрээр мэдээллийг цуглуулав.

ХДХВ, тэмбүүгийн халдвар илрүүлэх ийдэс судлалын шинжилгээнд эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ) 858, эрэгтэйтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэй (ЭБЭ) 167, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгч 2141, хөдөлгөөнт эрэгтэй 829, жирэмсэн эмэгтэй 409, цусны донор 400, сүрьеэтэй 143 өвчтөнийг хамруулав.

**Үр дүн:** ХДХВ-ийн халдвар ЭБҮ, хөдөлгөөнт эрэгтэйчүүд, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчид, жирэмсэн эмэгтэйчүүд, цусны донор, сүрьеэтэй өвчтөнүүдийн дунд 0%, ЭБЭ-ийн дунд 1.8%-тай илэрсэн. Тэмбүүгийн халдвар ЭБҮ-ийн дунд 18.3%, хөдөлгөөнт эрэгтэйчүүдийн дунд 1.7%, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчдийн дунд 6.9%, ЭБЭ-ийн дунд 5.4%, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд 1.7%, цусны доноруудын дунд 1.5%-тай байв. Заг хүйтэн, трихомониаз, хламидийн халдвар илрүүлэх полимеразын гинжин урвалын шинжилгээнд 257 ЭБҮ-ийг хамруулснаас хламидын халдварын тархалт 25.5%, трихомониазын халдвар 14.8%, заг хүйтний халдвар 15.6%-тай байна.

Зан үйлийн тандалт судалгааг ЭБҮ 722, ЭБЭ 209, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчид 2172, хөдөлгөөнт эрэгтэйчүүд 939 болон 15-24 насны гэр бүлгүй 2068 залуучуудын дунд явуулав.

ХДХВ-ийн халдвар, бэлгийн замаар дамжихаас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүмүүсийн эзлэх хувь ЭБҮ-ийн дунд 50.4%, ЭБЭ-ийн дунд 56.3%, хөдөлгөөнт эрэгтэйчүүдийн дунд 24%, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчдийн дунд 29.6%, 15-24 насны залуучуудын дунд 20.3%-тай байсан.

ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан хувь ЭБҮ-ийн дунд 74%, ЭБЭ-ийн дунд 78.6%, хөдөлгөөнт эрэгтэйчүүдийн дунд 27%, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчдийн дунд 31.5%, 15-24 насны залуучуудын дунд 11.7%-тай байв.

#### **Дүгнэлт:**

1. ЭБЭ-ийн дунд ХДХВ-ийн халдварын тархалт 1.8%-тай байгаа нь өмнөх онуудын ХТС-тай харьцуулахад ХДХВ-ийн халдварын тархалт нэмэгдэх хандлагатай байна.

2. ЭБҮ-ийн дунд тэмбүүгийн халдварын тархалт

бусад судалгаанд хамрагдсан бүлэгтэй харьцуулахад хамгийн өндөр, өмнөх онуудтай харьцуулахад тууштай буурахгүй байна.

3. 15-24 насны залуучуудын ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан байдал болон ХДХВ/ДОХ-ын талаар цогц, зөв мэдлэгийн түвшин өмнөх онуудтай харьцуулахад буурсан, судалгаанд хамрагдсан бусад бүлэгтэй харьцуулахад доогуур байна.

4. Иймд цаашид эрсдэлт бүлгийн хүн ам тэр дундаа ЭБҮ, ЭБЭ болон залуучуудын дунд ХДХВ-ийн халдвараас сэргийлэх, БЗДХ-ийг чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж эрчимжүүлэх шаардлагатай байна.

### **Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дундах ХДХВ, тэмбүү, гепатит В, С вирусийн халдварын тархалт, зарим эрсдэлт хүчин зүйлийн судалгааны дүн**

*Г.Эрдэнэтуяа<sup>1</sup>, Д.Наранзул<sup>1</sup>, Б.Цогтбаатар<sup>2</sup>, Ч.Эрдэнэчимэг<sup>1</sup>, Д.Даваалхам<sup>3</sup>*

<sup>1</sup> Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

<sup>2</sup> Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэтэй тэмцэх төсөл,

<sup>3</sup> Эрүүл Мэнд Шинжлэх Ухааны Их Сургууль

Манай улсад ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол 1992 онд бүртгэгдсэнээс хойш 2010 оны 3 сарын байдлаар 64 тохиолдол бүртгэгдэж, 9 хүн нас барсан байна. ХДХВ/ДОХ-тай бүртгэгдсэн хүмүүсийн 75.0% эрэгтэйчүүд байна. Үүний 84.0% нь эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүд байна.

**Зорилго:** Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд ХДХВ, тэмбүү, гепатитын В, С вирусийн халдварын тархалт, зарим эрсдэлт хүчин зүйлийг тогтоох зорилгоор дараахь зорилтуудыг шийдвэрлэв:

1. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд ХДХВ, тэмбүү, гепатитын В, С вирусийн халдварыг ийдэс судлалын аргаар тогтоох

2. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд гепатитын В, С вирусийн халдвар тархалтын зарим эрсдэлт хүчин зүйлийг судлах

**Материал, арга зүй:** Улаанбаатар хотод амьдарч буй эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд ХДХВ, тэмбүү, гепатитын В, С вирусийн халдварын тархалт, зарим эрсдэлт хүчин зүйлийг тогтоох судалгааг нэг агшингийн загвараар хийж